

Рагчаагийн Бигэрмаа
Хэлбичгийн ухааны доктор (Ph.D)
(ШУТИС, ГХС-ийн Ази судлалын салбар)
ORCID судлаачийн дугаар: ID 0000-0003-2033-5441
bigermaa@must.edu.mn, 99037603

**Монголын орчин үеийн яруу найраг дахь монгол соёлын зарим онцлог
(Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн яруу найргийн жишээгээр)**

Түлхүүр үг: *яруу найргийн дүрслэл, монгол ахуй, зан заншил, соёл*

Аливаа үндэстний уран зохиолын хөгжилд яруу найргийн төрөл чухал байрыг эзэлдэг. Яруу найраг нь тухайн ард түмний авьяас, оюуны соёл, сэтгэлгээний цар хүрээ, сэтгэх ба илэрхийлэх онцлог, гүн ухааны үзэл баримтлал, сэтгэлийн дотоод ертөнцийг бүхэлд нь багтаасан агуулгатай бөгөөд амьдрал, аж төрөхүйн учир шалтгаан, утга соёл, зан заншил, урлагийн өвөрмөц цогц байсаар иржээ.

Утга зохиолын ертөнцөд үе үеийн манлайлагч яруу найрагчид төрж, бичлэг сэтгэлгээ, дүрслэх ур маяг, урлах арга барилаараа ялгаран, үгийн урлагийн төрөлд онцгой, бие даасан үзэгдэл болохын зэрэгцээ тэрхүү манлайлагч зохиолчийн арга барилыг дагасан сэтгэлгээ, ур чадварын дэг сургууль аяндаа бүрдэж, өөрөө болон түүнийг залгамжлагчид утга зохиолд үнэтэй хувь нэмэр оруулах үзэгдэл байдаг. Үүнийг шинэчлэл гэнэ. Энэ нь өмнөх үеийн уламжлалтай нягт уялдаа холбоотой. Монголын орчин үеийн уран зохиол, ялангуяа яруу найраг ч энэхүү хөгжлийн зүй тогтлыг даган хөгжсөөр иржээ.

Монголчууд эрт язгуураасаа эх хэлний үгсийн эрдэм болох яруу найргаар хэлэлцдэг ард түмэн тул судлаачид яруу найргийн уламжлал, хөгжил, хувьслын асуудлыг судалж, сонирхолтой дүгнэлтүүдийг хийсээр ирсэн байна.

Яруу найргийн хөгжлийн үе бүхэн өөрийн гэсэн өвөрмөц арга барил, сэтгэлгээ бүхий тэргүүлэх яруу найрагчдыг төрүүлж, бичлэг, сэтгэлгээ, туурвил зүйн шинэчлэл хийгдсээр байдаг. Энэ утгаараа 1930-аад оны яруу найрагт Д.Нацагдорж, харин 1960-аад оны яруу найрагт Б.Явуухулан шинэчлэл хийсэн бол, 1990-ээд оны яруу найргийн ертөнцөд Б.Лхагвасүрэнг зүй ёсоор нэрлэж болно.

Энэхүү өгүүлэлд ХХ зууны 1980-1990-ээд оны яруу найргийн гол төлөөлөгч, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн уран бүтээлд дүрслэгдсэн монгол соёлын зарим онцлогийг тодруулахыг хичээлээ.

Монгол соёл нь монголын ард түмний сэтгэлгээний болон эд өлгийн өвөрмөц онцлогийг харуулсан олон талт, баялаг агуулга бүхий өргөн ойлголт бөгөөд байгаль, цаг уур, эрхэлж буй аж ахуйтай холбоотой нүүдлийн соёл иргэншилд тулгуурласан байдаг.

Б.Лхагвасүрэнгийн яруу найрагт Монголчуудын оюуны соёлын үнэт өв, сэтгэлгээний онцлог, бэлгэдэл зүй, тэрчлэн монгол бичиг, монгол гэр, үндэсний хувцас, хуур хөгжим, уртын дуу гэх мэт оюуны болон эд өлгийн соёл, монгол ёс заншил, үндэсний баяр наадам зэрэг олон зүйлийг дүрсэлснээрээ өвөрмөц онцлогтой. Жишээлбэл, нүүдэлчдийн үндсэн сууц болох гэр, түүнтэй холбоотой монгол зан заншил, бэлгэдэл зүйн тухай дүрслэл, мөн Монголчуудын ахуй амьдралын зураглалд тулгуурлан, монгол эмэгтэйн үйл мэтгэх урлаг, эх үрийн нандин холбоо, наран цаг, зүг чиг, тооны бэлгэдэл зэргийг тодруулахын тулд яруу хэрэглүүрийг хэрхэн хэрэглэсэн, үгийг яаж сонгосон зэрэг асуудлыг хөндөхөд энэхүү өгүүллийн үнэ цэн, шинэлэг тал оршино.